



Улсын хилийн онол,

тvvх

ХАЛХ ТУВАГИЙН ХИЛИЙН АСУУДАЛД.

Улсын хилийн түүх судлал бол эх орны түүх судлалын чухал нэгэн хэсэг бөгөөд улс төрийн түүхэн газар зүйн судлах гол зүйл мөн. Тийм ч учраас гадаад орнуудад энэ талаар их анхаарч, хөрш орон тус бүртэй хиллэсэн хилийн торгон шугам чухам хаагуур байж, хэрхэн өөрчлөгдөж ирсэн түүхийг зэргэлдээх орон орноор, үе үеэр нь нарийвчлан судалдаг байна.

Манай оронд БНХАУ-тай хиллэсэн хэсэгтээ бага зэрэг анхаараад ОХУ-тай хиллэсэн хилийг судлан тодотгох асуудлыг орхигдуулж иржээ. Монгол Улсын хилийн түүхийг тусгайлан судалсан хүмүүсийн нэг нь дэд эрдэмтэн Б.Цэдэн-Иш билээ. Энэ судлаач хилийн торгон шугам үүссэн, өөрчлөгдсөн түүхийг нэлээд тодорхой гаргасан боловч хил орчмын овог, аймгуудын нутагшил, тэдгээрийн нутаг шилжин суух хөдөлгөөний түүхийг дутуу дулимаг судалсан явдал зарим зүйл дээр харагдана.

Б.Цэдэн-Иш сүүлийн үест Оросын Холбооны Тува улстай Монгол Улсын хиллэсэн хилийн шугам, хил орчмын газар нутгийн түүхийн талаар эргэлзээтэй зүйл бичиж нийтлүүлэх болов.

Тэрээр "... Улаангомьн тариалангийн газарт 1759 онд Дөрвөдийн 2 аймаг 16 хошуу нь тэнд амьдрах байсан Түмэд Монголын тариачдын нутаг, эртний Алтан улсын газар дээр амьдарч сууж байсан Тагна Урианхай нарын тал нутгийг эзэлж авсаныг эрдэмтэн Майский, Ц.Жамсранов нар түүхчлэн тодорхойлсон байдаг /9/ хэмээн Хотгойдын Алтан ханы улсыг Алтан улс гэж бичсэн нь хүмүүст 1616 онд зүүн хойд хятадын нутагт байгуулагдсан Зүрчидийн Алтан улстай хутгаж ойлгогдохоор болжээ. Мөн тус өгүүлэлд академич И.М.Майскийн Хангилцагийн голд удаан хугацаагаар сууж, Тагна уулын Урианхайн болон Халх, Дөрвөдийн хил орчмын ард түмний түүхийг судлаад "Тагна Урианхайчууд түрэг хэлээр ярьдаг, тэд Тагна уул Соёны нурууны хооронд нутаглана. Тэдний зарим хэсэг Тагна уулыг давж, Тэс голын хөндийд нүүж очсон. Дөрвөдүүд ирэхээс өмнө Хан Хөхийгөөс Тагна уул хүртэл нутагт Урианхайчууд байсныг Дөрвөдүүд ирж тэднийг хойд зүгт Тагнын нуруу руу шахаж нутаглахад, хүргэсэн /, х 34/ хэмээн бичсэнийг гуйвуулж, Улаангом, Увс нуурын хавь нутаг нь Тагна

Урианхайн уугуул нутаг бөгөөд тэр нутгийг дөрвөдүүд түрэмгийлэн эзэлсэн юм гэсэн санааг тодорхой тусгажээ.

Б.Цэдэн-Иш цааш нь "ууланд шахагдсан Урианхай нар уугуул нутгаа эгээрэн хүсэж Улиастайн цэргийн жанжны газар, аймгийн чуулганд олон удаа үнэн хүсэлтээ өргөн айлтгаж байжээ" хэмээн Увс нуурын орчим, Хан Хөхийн нуруу нь Монголчуудын нутаг биш харин Тагнын урианхайн уугуул нутаг мөн гэж батлахыг оролдсон байна.

Увс нуур, Хан Хөхийн нуруу нь эртнээс Монголчуудын газар нутаг байсан ба Гэрсэнэжалайр хунтайжийн ахмад хүү Ашихай дархан хунтайжийн мэдэлд байсан Халхын баруун гарт багтаж яваад дараа нь түүний хөвгүүн Түмэн дарь дайчингийн хүү Шолой убашийн эзэмшилд оржээ. Шолой убашийн орд өргөө нь Увс нуурын баруун хөвөөнд /одоогийн Давст сумын нутаг/ байсан хэмээн Орос улсын элчин В.Тюменец, И.Цеплин нар тэмдэглэсэн /1, х13-18/ байдаг. Мөн Зүүнгарын Галданбошгот хаан Увс нутагт цэргийн тариалан тариулж байсны ул мөр эдүгээ хүртэл "Бошготын тариг" нэрээр хадгалагдсаар иржээ. /6/

"Мэйрэний занги Усан цэрэг авч Улаангомын хязгаараар гарч урианхай ардын хураан авсан нь маш үзэмж /2/. "Мөнөөхөн алсан дагуулсан Урианхайн хоёр мянга таван зуун гучин нэгэн хүнийг манж цэрэг гурван зуу, халхын цэрэг хоёр зууг гаргаж, эднийг Баянзүрхийн газарт хүргэж суулгасугай" зэрэг мэдээнээс харахад Манжууд Тагна Урианхайчуудыг хэсэг хэсгээр нь олзлон авч Увс, Хан Хөхийн хавьд дотогшлуулан суулгаж байжээ.

1753 онд Манжид дагаар ороод Заг Байдрагт нутаглаж байсан Дөрвөдүүдийг 1758 онд Увс нуурын газар шилжүүлэн суулгажээ. Энэ тухай Манжийн Тэнгэрийг тэтгэсэн хаанаас Тагна Урианхайн Ноён Цэдэгт "Урьд танай нутгийг дотогш шилжүүлж суулгасан нь чухам хулгай нар зовоох болов уу хэмээн учир бүлгээ. Эдүгээ дотоод гадаад огт ялгаварлах газаргүй, цөм миний газар болой. Үүнд шинэ хуучин урианхай нэр эсвээс одоо суусан газраа өчүүхэн чинагш шилжиж суусугай хэмээх болбоос цөм болмой" /3/ хэмээн тэднийг урьд нааш татан суулгасан эдүгээ цааш нь буцаах болсноо мэдэгджээ.

"...Дөрвөдийн хан Цэрэн нар, тэд угаас хасаг өөлд нарт өшөө буй, эдүгээ эдний урвасныг сонсож, тэдний нутгийг Улаангомын газрыг шилжүүлмүү хэмээн гуйсан явдлыг айлтгажээ. Үүнийг тэдний гуйсан ёсоор Улаангомын газарт суулгаж, ойр цөмийг шагнаж тариалан тариултугай." /3/ гэсэн Тэнгэрийг тэтгэсэн хааны зарлигаар Дөрвөдүүд Улаангом, Хан Хөхийн нутагт очиж сууснаар урьд нь авчирч суулгасан

Тагна Урианхайчуудыг цааш явахад хүргэжээ. Ийнхүү Манжууд Тагнын Урианхайг Оросод дагаар орох буюу Зүүн гарт урвахаас сэргийлэн зарим хэсгийг нь Улаангом, Хан Хөхийн нутаг татан суулгаад хожим нь Бүх монголыг захиргаандаа оруулсны дараа уг нутагт Дөрвөдүүдийг суулгаж Урианхайчуудыг уугуул нутаг Тагна уул руу нь шахсан байна. Үүнээс хойш ч гэсэн Манжийн захиргаанаас Тагна Урианхайн малчдыг цас зуднаас зайлуулж Халхын нутаг руу нүүлгэн дотогшлуулах явдал гарсаар байв.

Б.Цэдэн-Иш "Халхын Засагт хан чуулганы дарагас 1775 оны 4 сарын 17-нд гаргасан бичигтээ: "Урианхайн Манги даргатай сумын ардуудыг Монголын Замбага даргатай хошууны ардуудтай найрсагаар хамтран нутаглахыг зөвшөөрсөн бөгөөд 1842 оны 11 сарын 26-нд гаргасан бичигтээ: Урианхайн Бүргэд даргатай сумын ардуудад Хан Хөхийн нурууны хойд зүгт Хангилцаг зэрэг газруудыг олгож нутаглахын зөвшөөрөн тушаасан байна." гэжээ. Энд Хангилцагийн газарт Урианхайг түр суулгасан нь үнэн боловч орон нутгаас олдсон лавтай мэдээллээр бол Засагт хан аймгийн Ачит вангийн ноёд эдгээр Урианхай нарыг удалгүй нутгаасаа шахаж Алтан элсний цаана гаргасан байна. Энэ мэдээ үнэн болох нь 1913 онд үйлдсэн нутгийн зургаас /8/ тодорхой байна. Энэ зурагт Ачит вангийн хошууны нутгийг Алтан элсийг өнгөртөл зурсан төдийгүй хошууны ноёны орд өргөө, хошуу тамгын газрыг Хан Хөхийн ар бэл, Зүүн Турууны голын адаг, Алтан элсний наахна байгаагаар тэмдэглэжээ.

Б.Цэдэн-Иш "... 1770 оноос нутаглаж ирсэн Урианхайн ардуудын өссөн төрсөн газар шорооноос хөөн зайлуулж үл болох нь мэдээж бизээ". гэж Улаангом, Хан Хөхий хавь нутгийг өөрсдийн хүсэлт буюу бусдын хүчинд автан-түр хугацаагаар нутаглан сууж байсан Тагна Урианхайчуудын "өссөн төрсөн газар шороо байсан" гэж өрөөсгөлөөр дүгнэсэн байна.

Мөн нөгөөтэйгүүр 1759 онд Дөрвөд, Тагна Урианхайн хоорондох хилийг тогтоож Халхын цэргийн харуулуудаар хамгаалуулсан гэж энэ эрдэмтэн үзсэн нь умард хилийн торгон шугамын үүсэл болон хилийн харуулууд буй болсон цаг үетэй зөрж байна. Дөрвөд, Тагна Урианхайн хилийг 1759 онд тогтоогоогүй, харин 1689 онд Нерчүүгийн гэрээнээс хойш 1727 онд Манж-Оросын хил тогтоохоос өмнө нутгийн зааг хил хэлбэржин тогтож Халхын хилийн харуулууд нутгийнхээа захыг сэргийлэн суух болсон болов уу.

1727 оны Буурын гэрээгээр Тагна Урианхай, Хөвсгөлийн Дархад, Урианхай, Халхын нутгийн хойгуур хил тогтоогоод, Халхын харуулуудаар хамгаалуулсан байдаг. Иймд Тагна Урианхай,

Хөвсгөлийн Дархадын урдуур, Хөвсгөлийн Урианхайн нутгийн дундуур байгаа хилийн харуулуудыг дан ганц Тагна Урианхайг Дөрвөдөөс Богдын шавийг халхын хошуудаас зааглах зорилготой хэмээн үзэх нь асуудлыг ганцхан талаас нь авч үзсэн хэрэг болох бизээ. Нөгөөтэйгүүр Дөрвөд, Тагна Урианхайн хоорондох нутгийн харуулын хайчийн зам нь улсын хил бус харин Манж гүрний захиргаан дахь хоёр эзэмшлийн хоорондох нутгийн зааг бөгөөд жинхэнэ улсын хил нь 1727 онд тогтсон ба Тагнын нурууны өвөр этгээдээр Дөрвөд, Тагна Урианхайн нутаг зааглагдаж байжээ. /5, х 49/

Дөрвөд, Тагна урианхайн нутгийг зааглан чанд хамгаалж байсан Халхын харуулуудын гол үүрэг нь улсын хилийг буюу Тагна Урианхайн нутгийн хойгуур тогтоосон хилийг хамгаалах явдал байв. Халхын Зах Хөвөлзөхийн Архан буурал хүртэлх 36 харуул хилийн шугамд ойр Оросын хилийн харуулын тосгодтой харалдаа байрлан хил хамгаалж байсан бол Арханбуурлаас баруун тийш Асгатын даваа хүртэл харуулууд Халхын хойд этгээд дэх нутгаасаа хол очиж алба үүргээ гүйцэтгэдэг байжээ. Хөвсгөл нуурын баруун урд этгээдийн Бэлтэс харуулынхан Монголын Шарын даваан дээр, Хатгал боомт харуулынхан Ханхын хойд хил дээр, Уйлган харуулынхан Уйлган голын эхэнд тус тус Оросын харуултай 3 жилд нэг удаа “Эв модны наадмыг” хийж байсан тухай мэдээ бий. /7, х. 10/

Манж-Оросын хилийг Тагна Урианхай, Хөвсгөлийн дархад, Урианхайн нутгийн хойгуур тогтоосон атлаа хилийн харуулуудын хил рүү, дээрх нутгуудын хойд талд шилжүүлэн байрлуулсангүй хуучин байрнаас нь хил хамгаалах үйл ажиллагааг эрхлүүлэх болгосон нь зүй ёсоор анхаарал татаж байна. Үүнд байгаль, газар зүйн орчин, газрын бартаа, бэрхшээл нөлөөлсөн байж болох боловч Хаант Оросоос Тагна Урианхай, Хөвсгөл нутгийг эзлэн авах хэтийн зорилгоор Баруун Монголтой байлдах бэлтгэл хийж байсан Манжид шахалт үзүүлэн хилийн харуулуудыг дээрх нутгуудын урдуур хэвээр нь суулгасан бололтой. Хаант орос энэ зорилгоо олон жилийн дараа зарим талаар /1914 онд Туваг хараат болгосноор/ хэрэгжүүлж чадсан юм. Манж улс ч Оростой бат найрамдал тогтоох замаар Зүүнгарын хаант улсыг ганцаардуулан эзлэн авахын үүднээс Тагна Урианхай, Хөвсгөлийн нутгийн хойгуур хилийн харуулуудыг тавих асуудалд буулт хийхэд хүрчээ гэж үзэж болно.

Халхын харуулуудын оршиж байсан газар нутаг нь хилийн шугам биш юм. Эдүгээгийн Монгол Улсын хилийн отряд, заставууд хилийн шугам дээр байрладаггүйн адил тэр үеийн харуулын нутаг нь харуулынхны амьдрал ахуйгаа эрхлэн хөтлөхөд зориулан олгосон

тусгай зураг, цэс бүхий нутаг юм. Суман харуулд хэдийгээр гэр харуул шиг том нутаг байхгүй боловч орших суух, алба, амины мал сүргээ адгуулах тодорхой хэмжээний газартай байжээ. Иймд хилийн харуулуудын суурьшин асан нутгийг улсын хил гэж үзэх нь түүхийн үнэнтэй зөрчилдөн улсын хилийн нутгаа тануулахад хүрч байгааг эрхиш анхаарч үзүүштэй.

Ном зохиол

1. А.Г.Банников. Первое русские путешествия в Монголию и Северную Китай. М., 1954
2. Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг. Өмнөд зохиол 9-р дэвтэр.
3. Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг. Жинхэнэ зохиол. 49-р дэвтэр.
4. И.М.Майский. Монголия накануне революции. М., 1960
5. В.В.Мойсеев. Цинская империя и народы Саяно-Алтай 18 в. М., 1983.
6. А.Очир Үнэнээр гул бариад хол явахгүй. Монголын залуучууд. 1991. № 34
7. О.Пүрэв. Эв модны наадам. Залгамжлагч. 1985 № 5
8. УТИС. Засагт хан аймгийн 20 засаг хошуу, 3 Хутагтын шавийн нутагласан газар орныг хураангуйлсан зураг.
9. Б.Цэдэн-Иш. Үнэнийг өгүүлнэм. Монголын залуучууд. 1991. № 14.

Дэд доктор Ж.Гэрэлбадрах

МОНГОЛ УЛС, ОХУ, БНХАУ-ЫН ХИЛИЙН ЗҮҮН УУЛЗВАРЫН ЦЭГИЙГ ТОГТООЖ ТЭМДЭГЛЭСЭН НЬ

Монгол, Орос, Хятад улсын хилийн уулзваруудын хоёр цэгийн бодит байдлыг тодорхойлохын тулд Талуудын хамтарсан ажлын хэсэг байгуулахаар шийдэж гурван улсын хилийн Зүүн уулзварын тодорхойлолт-протоколд хавсаргах 1:100 000-ны масштабтай газрын зураг үйлдэн Зүүн уулзварын цэгт хилийн "Тарваган дах" тэмдэг босгож, уг хилийн тэмдгийн протокол үйлдэхийг тус тус хариуцуулжээ.

Гурван улсын хилийн Зүүн уулзварын цэгийн тухай Тодорхойлолт-протоколд "... Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хилийн Зүүн уулзварын цэг нь 645.0 тоот бүхий өндөрлөгт дээрх "Тарваган дах" овооны төвд оршино.